



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд
хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт
болон 2018 онд хөгжүүлэх
үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "д", 18.1.2 "а" дах хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дах хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дах хэсгүүдийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. "Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтийг "Бүрэн хангалттай" гэж дүгнэсүгэй.
2. "Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.
3. Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга /Г.Баясах/-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Г.Болормаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ГАНЧИМЭГ

4130100034

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
8 дугаар хуралдааны 2017 оны 12-р сарын 19-ний
өдрийн 17-р тогтоолын нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

№	Дүүргийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх түвшин, үр дүн	Хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах байгуулл ага
НЭГ. ЭРҮҮЛ МЭНД						
1.1 Иргэдийг өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хороодын өрхийн эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.						
1	1.1.1 Өрхийн эмнэлгийн барилгын хүртээмжийг нэмэгдүүлэх, эмнэлгүүдийн анхан шатны үзлэг оношилгооны тоног төхөөрөмжийг сайжруулж, нэмэгдүүлнэ.	Эмнэлгүүдийн анхан шатны үзлэг оношилгооны тоног төхөөрөмжийг сайжруулж, нэмэгдүүлнэ.	Нийлүүлэх тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо	3-5	Улс, нийслэлийн төсөв	НХХ, ЭМТ
2	1.1.2 Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж, хүний нөөцийг чадваржуулна.	Дүүргийн амбулаториуд, өрхийн эмнэлгүүдийн эмч, сувилагч, асрагч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшсэн боловсон хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэн ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Улс, нийслэлийн төсөв	НХХ, ЭМТ
3	1.1.3 "Цахим эрүүл мэнд" хөтөлбөрийн хүрээнд өвчний түүхийг цахим мэдээллийн системд бүртгэх, дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн технологийг боловсронгуй болгож, чирэгдлийг бууруулна.	Иргэдэд эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор эрүүл мэндийн цахим үйлчилгээг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Улс, нийслэлийн төсөв	НХХ, ЭМТ

4	1.1.4 Эрүүл мэндийн салбарын авлига, хээл хахуультай иргэдийн мэдээлэл хяналтын дор тууштай тэмцэнэ.	Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлын мэдээ тайланг вэйб хуудас болон ил тодын самбарт тогтмол байршуулан авлига, хээл хахуультай холбоотой иргэдээс ирүүлсэн мэдээллийг нээлттэй хүлээн авч, дотоод хяналтыг сайжруулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	НХХ, ЭМТ
5	1.1.5 Дүүргийн хүн амын дунд өргөн тархацтай байгаа өвчин эмгэгийн үүсэх шалтгаан нөхцөлд тандалт судалгаа хийж, нөлөөлж буй сөрөг үр дагаврыг багасгахад анхаарч ажиллана.	Иргэдэд аливаа халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх дадал, зуршил бий болгох мэдлэг мэдээллийг олгоход анхаарч ажиллана.	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хувиар	-	-	НХХ, ЭМТ
6		Хатгалгаа өвчний эсрэг хөгжлийн мэдээлэл харилцааны арга хэмжээг, хатгалгааны эсрэг вакцин нэвтрүүлэх, эцэг эхийн мэдлэгийг сайжруулах, төсвийн хуваарилалтыг сайжруулах, шинээр нэвтэрч буй вакцины олон хатгалттай холбоотой иргэд, эрүүл мэндийн ажилтануудын айдсыг арилгахад туслах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв, НҮБХС	НХХ, ЭМТ
7	1.1.6 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	5-6 насны хүүхдийн амны хөндийн өвчлөлийн бууралт, хувиар	Өмнөх оны мөн үеэс 2%аар бууруулна.	-	НХХ, ЭМТ
8	1.1.7 Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.	Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний чанар болон тоог нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	НХХ, ЭМТ
1.2 Нийтийн биеийн тамир, спорт.						

9	1.2.1 Дүүрэгт баригдаж буй спортын цогцолбор болон биеийн тамир спортын талбай барих ажлыг үе шаттай хэрэгжүүлж ашиглалтад оруулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж буй спорт цогцолборын барилгын ажилд хяналт тавьж ажиллана.	Спортын ордны барилгын ажлын явц, хувиар	70	Улсын төсөв	НХХ, ТГХШХ
10	1.2.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв 15,000,000	НХХ, БТСХ
11	1.2.3 Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үндэсний болон өвөл, зуны спортын төрлөөр уралдаан тэмцээн жил бүр зохион байгуулна.	Үндэсний болон өвөл, зуны спортын төрлөөр уралдаан тэмцээн тухай бүр зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ, БТСХ
12	1.2.3 Өсвөр үе, хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, авьяас, ур чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг багийн спортоор дамжуулан хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, үндэсний болон өвөл, зуны спортын төрлөөр уралдаан тэмцээн жил бүр зохион байгуулна.	Ерөнхий боловсролын сургуулийн баг тамирчдын дунд сагсан бөмбөгийн лигийн аврага шалгаруулах тэмцээнийг зохион байгуулна.	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	1	Орон нутгийн төсөв	НХХ

ХОЁР. БОЛОВСРОЛ

2.1 Цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр улсын төсөв, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ.

13	2.1.1 Улсын төсөв, төрийн өмчийн концесс, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих замаар дүүрэгт сургуулийн барилга шинээр барих, сургуулийн өргөтгөл барих ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, сургуулиудыг хоёр ээлжид шилжүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улс, нийслэл, гадаадын болон хувийн хөрөнгө оруулалтаар дүүрэгт хэрэгжих сургууль, цэцэрлэгийн барилга, өргөтгөлийн ажилд хяналт тавьж ажиллана.	Барилга угсралтын ажил эхлүүлэх сургууль, тоо	2	Улсын төсөв	ТГХШХ, НХХ, БХ
			Сургуулийн спорт заал, тоо	2		
			Сургууль, өргөтгөл	6		
			Барилга угсралтын ажил эхлүүлэх цэцэрлэг, тоо	3	Улсын, нийслэлийн төсөв.	ТГХШХ, НХХ, БХ
14	2.1.2 Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийн хүрээнд дүүргийн цэцэрлэггүй хороодод цэцэрлэг барих, төрийн өмчийн цэцэрлэгийг түшиглэн гэр цэцэрлэг	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хүүхдэд зориулан хувилбарт сургалтуудыг зохион байгуулна.	5 настай хүүхдийг хамруулах хувь	Өмнөх жилийн мөн үеэс 3 хувиар нэмэгдүүлнэ	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ, БХ

15	байгуулах ажлыг зохион байгуулж, хүүхдийг хөгжүүлэх зардлыг нэмэгдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан явуулын багшийн сургалтыг эхлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв	НХХ, БХ
16		Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас сургууль, цэцэрлэг байгуулах үйл ажиллагааг дэмжиж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	НХХ, БХ
2.2 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.						
17	2.2.1 “Эко сургууль”, “Ногоон цэцэрлэг” аян хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэг бүрд хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бий болгон, сургалтын орчны шинэчлэл хийнэ.	“Эко сургууль”, “Ногоон цэцэрлэг” аяны хүрээнд сургууль, цэцэрлэгийн орчныг эрүүл аюулгүй, хүүхдэд ээлтэй байх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Улс, нийслэлийн төсөв	НХХ, БХ
18	2.2.2 Сургуулийн бүсэд аюулгүй байдлыг бүрэн хангасан стандарт нэвтрүүлж, цэцэрлэг, сургуулийн орчныг гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгох ажлыг зохион байгуулна.	Сургуулийн цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангаж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Улс, нийслэлийн төсөв	НХХ, БХ
19	2.2.3 Хүүхдийн насны онцлог тохирсон хөгжлийн хөтөлбөрийг үндэсний өв уламжлал, ёс заншилтай хослуулан хэрэгжүүлж, эрүүл чийрэг бие бялдартай, боловсролтой, амьдрах ухаантай, эх оронч, нийслэлийн бүтээлч иргэнийг төлөвшүүлнэ.	Дүүргийн ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд үндэсний өв уламжлалт ёс, заншлыг сурталчилах, эрүүл чийрэг бие бялдартай эх оронч иргэнийг төлөвшүүлэх ажлуудыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ
20	2.2.4 Хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор дугуйлан секцийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Дүүргийн “Соёлын ордон”-ны тоног төхөөрөмжийг сайжруулах, дуу болон бүжгийн дугуйланг тогтмол чанартай хичээллүүлж хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Дугуйланд хамрагдах хүүхдийн тоо	90	Орон нутгийн төсөв	НХХ, СО
21	2.2.5 Хүүхдийг осол гэмтэл, мансуурал, донтолт, болзошгүй эрсдэл, цахим орчны сөрөг нөлөөнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, эрсдэлд өртсөн хүүхдэд үзүүлэх нөхөн сэргээх	Хүүхдийг осол гэмтэл, мансуурал, донтолт, цахим орчны сөрөг нөлөөний нөхцөл байдлын судалгааг хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв	НХХ

	үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.					
22	2.2.6 Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, хариу үйлчилгээний чанарыг сайжруулах замаар хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх, хороодын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулж үйл ажиллагааг эрчимжүүлж эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.	Суурь судалгаанд тулгуурлаж тоог бууруулна.	100	Орон нутгийн төсөв	НХХ
23	эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн чиглэлээр гарч буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэдэд энэ чиглэлээр ойлголт мэдээллийг хүргэх хандлагыг өөрчлөх сургалтыг зохион байгуулна.	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	3-5	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ
24	2.2.7 Хараа хяналтгүй, эрсдэлд өртсөн хүүхдийг шуурхай хамгаалан, үйлчилгээ үзүүлэх нэгжийг бий болгоно. Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд гэр бүлийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлж, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэнэ.	Хараа хяналтгүй болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хамгаалах үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн асрамж, халамжийн төвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүүхдийг эцэг эх гэр бүлд нь эргэн нэгтгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв.	НХХ
2.3 Сургалтын чанарыг сайжруулна.						
25	2.3.1 Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлнэ.	Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын “Цөм хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв	НХХ, БХ
26	2.3.2 Сургалтын хөтөлбөрт түүх, хэл соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, үндэсний ухамсар, эх оронч сэтгэлгээг суулгахад чиглэгдсэн агуулгыг тусган хэрэгжүүлнэ.	Дүүргийн ЕБС-уудын бага ангийн сурагчдын дунд “Би монгол хүүхэд” ёс заншлын наадам зохион байгуулах, ЕБС-ийн 1-12 дугаар ангийн сурагчдын дунд “Их нүүдэл” шатрын тэмцээн зохион байгуулна.	Зохион байгуулах арга хэмжээ, тоо	2	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ, БХ
27		Үндэсний өв соёлоо дээдлэн, эх оронч үзэл санааг олгоход чиглэсэн “Монгол ёс заншлын өдөрлөг”-ийг ЕБС-уудад зохион байгуулан ажиллана.	Сургууль тус бүр нэг удаа	100	-	НХХ, БХ
28	2.3.3 “Хүн болох багаасаа” аян өрнүүлж, хүүхдийг амьдрах ухаан, бие даах чадвар, харилцааны зөв дадал хэвшилд сургаж, үндэсний бахархал,	Сургууль болон байгууллага түшиглэсэн секц, дугуйлангийн нэр төрөл, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Улс, нийслэлийн төсөв	НХХ, БХ

	глобал сэтгэлгээтэй иргэн болгон төлөвшүүлнэ.					
2.4 Багшийн мэргэжлийг дээшлүүлж, сургалтын орчныг сайжруулна.						
29	2.4.1 Сургууль, цэцэрлэгийг чадварлаг боловсон хүчин, сургалтын орчинтой болгох "Нийслэлийн боловсрол-2024" хөтөлбөр хэрэгжүүлнэ. Олон улсын хөтөлбөрт сургуулийн тоог нэмэгдүүлнэ.	Өмчийн бүх хэлбэрийн ЕБС, цэцэрлэгүүдэд "Нийслэлийн боловсрол 2020" хөтөлбөрийг хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв	НХХ, БХ
30	2.4.2 Багшийн мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад дүүргийн багш нарыг урт болон богино хугацааны сургалтад хамруулна. Олон улсын, улсын болон нийслэлийн шилдэг мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж, багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.	Багшийг өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад урт болон богино хугацааны сургалтад хамруулах, туршлага судлуулах, олон улсын, улсын болон нийслэлийн шилдэг мэргэжилтний багийг урилгаар ажиллуулж, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.	Сургалтад хамрагдах багшийн тоо	30	Улс, нийслэлийн төсөв	НХХ, БХ
2.5 Иргэний боловсрол олгох албан бус сургалтын үйл ажиллагааг дэмжин ажиллана.						
31	2.5.1 Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад сурагчдыг ажил мэргэжлээ зөв сонгоход туслах зөвлөн туслах үйлчилгээг нэвтрүүлнэ.	Дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад сурагчдыг ажил мэргэжлээ зөв сонгох сургалт зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан сурагчдын тоо	1000	Нийслэлийн төсөв	НХХ, БХ, ХХҮХ
32	2.5.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулж, төгсөгчдийг ажлын байраар хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Ажлын байранд хамрагдсан тоо	48	Нийслэлийн төсөв	НХХ, БХ, ХХҮХ
33	2.5.3 "Насан туршийн боловсролын төв"-өөр олгох сургалтын хүртээмжийг сайжруулж, дүүргийн хэмжээнд сургууль завсардалтыг бууруулна.	Насан туршийн боловсрол олгох амьдрах ухааны сургалтуудыг иргэдэд тогтмол зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ, БХ
34	2.5.4 "Хүмүүнлэгийн боловсрол" олгох үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай хамтран ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	НХХ, УЗХ
2.6 Соёлын хүртээмжийг нэмэгдүүлж, "Хотын соёл"-ыг төлөвшүүлнэ.						
35	2.6.1 Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян	"Хотын соёл" олон нийтийн аяны хүрээнд "оюутан залуучууд сурагчдын дунд "Архигүй, тамхигүй Монголын төлөө хамтдаа" цуврал сургалт өдөрлөг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ, БХ

	өрнүүлнэ.					
36	2.6.2 “Соёлын өвд ээлтэй Улаанбаатар” аян хэрэгжүүлж, түүхэн хөшөө, дурсгалт талбайг сэргээн засварлаж, соёлын аялал жуулчлалын эргэлтэд оруулна.	Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад анхаарч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	НХХ, ТНААХ
2.7 Гэр бүлийн үнэт зүйлийг бэхжүүлж, тогтвортой гэр бүлийг дэмжинэ.						
37	2.7.1 Дүүрэгт “Гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэхийг хэвшүүлж, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бий болгож, тогтвортой харилцааг төлөвшүүлнэ.	Дэлхийн “Гэр бүлийн” өдрийг угтан ажлын төлөвлөгөө гарган сарын аян, уулзалт, өдөрлөг, гэр бүлд зөвлөгөө өгөх, гэр бүл төлөвлөлтийн сургалтуудыг зохион байгуулна.	Зохион байгуулсан сургалтын тоо	30	Нийслэлийн төсөв	НХХ
38	2.7.2 Гэр бүлд зөвлөгөө өгөх, эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ, гэр бүлийн боловсрол олгох, зан үйл засах, эерэг харилцаа, хүмүүжлийн эерэг арга эзэмшүүлэх сургалтын тогтолцоог төр, хувийн хэвшлийн оролцоотой бүрдүүлнэ.	Гэр бүлийн боловсролын талаар хүүхэд, эцэг эх, нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтуудыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	НХХ
ГУРАВ. ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИН						
3.1 Хөрсний бохирдлыг бууруулж, ногоон хөгжлийг дэмжин иргэдийн ая тухтай амьдах нөхцөлийг бүрдүүлнэ.						
39	3.1.1 Хотын тоосжилтыг бууруулах зорилгоор гудамж талбайг зүлэгжүүлж, бичил цэцэрлэг байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Орон сууц, гэр хорооллын нийтийн эзэмшлийн талбайд тохижилт бүхий, тоглоомын талбай байгуулна.	Шинээр байгуулах болон засварлах бичил цэцэрлэг, хөшөө дурсгалын тоо	15	Улс, нийслэл, орон нутгийн төсөв	ТНААХ
40		Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлах болон дүүргийн өмчид бүртгэлтэй хөшөө дурсгал, усан оргилуур, тоглоомын талбайг нөхөн сэргээх, засварлах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.				ТНААХ
41	3.1.2 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авна.	Нийтийн эзэмшлийн талбайн хөл газрын хогын ургамлыг хадаж цэвэрлэнэ.	Талбайн хэмжээ	500.000 м ²	Нийслэл, орон нутгийн төсөв	ТНААХ

42	3.1.3 Эзэнгүй нохой, муурын тоог зохистой түвшинд байлгах арга хэрэгслийг нэвтрүүлнэ.	Эзэнгүй нохой, муурын тоог зохистой түвшинд байлгах талаар холбогдох байгууллагатай хамтарч ажиллана.	Эзэнгүй нохой, муурын тоог бууруулах	8000	Нийслэлийн төсөв	ТНААХ
43	3.1.4 Мод тарьсан, ногоон байгууламж бий болгосон иргэд, байгууллагыг урамшуулах тогтолцоог оновчтой зохион байгуулна.	Мод тарих, ногоон байгууламж бий болгосон иргэд, байгууллагыг дэмжиж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	ТНААХ
44		Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа СӨХ, иргэдийн бүлгүүдийн дунд тохижилт ногоон байгууламжийн чиглэлээр болзолт уралдаан зохион байгуулж, хийсэн ажлуудыг нь олон нийтэд сурталчлах, тухайн орчинд тохижилтын чиглэлээр төсөл хэрэгжүүлж урамшуулах ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ДХТ
45		Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрүүдийн судалгааг гарган, дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтран төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт хийнэ.	Шалгалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	2 удаа 100	Нийслэл, орон нутгийн төсөв	ТНААХ
46	3.1.5 Байгаль орчин, эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг авто засвар, авто үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад үйл ажиллагааны ангилал тогтооно.	Нийт авто засварын үйлчилгээ эрхэлдэг байгууллагын хамрагдалтын хувь	30 хувь	Орон нутгийн төсөв	ХХҮХ
47		Авто засвар, авто үйлчилгээний байгууллагуудын стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт зохион байгуулна.	Шалгалт, үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	2 удаа 100	Орон нутгийн төсөв	ХХҮХ
3.2 Хог цэвэрлэгээ, тээвэрлэлт.						
48	3.2.1 Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хог тээвэрлэлт, цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэн, тоног	Нийтлэг үйлчилгээний газруудын албан хаагчдын тоо, тоног төхөөрөмжийг нэмж, зам талбайн үйлчлэгч нарын	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн	ТНААХ НҮГ-1,2,3,4

	төхөөрөмжийг нэмэгдүүлж үйлчлэгч нарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллана.	аюулгүй ажлын хувцас хэрэгслээр иж бүрэн хангаж ажилчдын ажиллах нөхцөл, стандартын шаардлагыг хангана.			төсөв	
49		Нийтийн эзэмшлийн зам талбай, айл өрхийн хог хаягдлыг хуваарийн дагуу шуурхай ачиж тээвэрлэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ТНААХ НҮГ-1,2,3,4 Хороод
50	3.2.3 Орчны бохирдол, гуу жалга, далан суваг, үүсмэл болон хур хогийн цэвэрлэгээг сайжруулж, хогийн цэг үүсэх нөхцөлийг арилгана.	“Шинэчлэн батлагдсан Хог хаягдлын тухай” хуулийг олон нийтэд сурталчилж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж цэвэрлэгээ тогтмол зохион байгуулж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	ТНААХ НҮГ-1,2,3,4 Хороод
51	3.2.4 Гэр хорооллын хүн амын суурьшлын бүсэд төвлөрлийн зэргийг тодорхойлж, хэрэгцээт газарт ус түгээх худгийн тоог нэмэгдүүлнэ.	Гэр хорооллын хороодын хүн амын суурьшлын бүсэд ус түгээх байрыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ТНААХ, Хороод
52	3.2.5 Улаанбаатар хотын хөрсний ус зайлуулах байгууламж, борооны ус зайлуулах шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, Ганц худгийн үерийн хамгаалалтын барилга байгууламж шинээр барина.	Ганц худгийн үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний ус, борооны ус зайлуулах шугам сүлжээний ажилд хяналт тавьж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	Улс, нийслэлийн төсөв	ТНААХ, ОБХ, ГА

ДӨРӨВ. НЭЭЛТТЭЙ ДҮҮРЭГ

4.1 Хороод иргэддээ нээлттэй иргэдийн оролцоотой асуудлаа шийддэг, дүүргийн үйл ажиллагаа ил тод, төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварын нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд цогц хүртээмжтэй хүргэнэ.

53	4.1.1 Дүүргийн удирдлагын зүгээс гарсан шийдвэрийн ил тод нээлттэй мэдээлж иргэдийг тухай бүр танилцах боломжоор ханган ажиллана.	Дүүргийн цахим хуудсыг тогтмол ажиллуулан мэдээ, мэдээллийг хороодын цахим сайт болон олон нийтийн телевиз, өдөр тутмын хэвлэлээр тогтмол хүргэж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв.	ТЗУХ, ХМА
54	4.1.2 Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” /KPI/-ээр үнэлж, хүний нөөцийн бүртгэл, хяналт, удирдлагын нэгдсэн сан бий болгоно.	Хүний нөөцийн бүртгэл, хяналт, удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлж, албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” /KPI/-ээр үнэлэх аргачлалаар үр дүнг тооцож ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ТЗУХ

55	4.1.3 Нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцох, хяналт тавих тогтолцоог бий болгож, нээлттэй засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.	Дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтын мөрөөр хяналт тавьж шийдвэрлэж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ТЗУХ
56	4.1.4 Төрийн захиргааны албаны бүх шатны албан хаагчид, өөрийн хариуцсан албан үүргийн хүрээнд иргэдэд төр, засгийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, нийтэд сурталчлах, мэдүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд камерын хяналтын системийг үргэлжлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэл, орон нутгийн төсөв	ТЗУХ
57		Хороодын Иргэний танхимтай хамтран улирал бүр иргэдэд зориулан хууль, эрх зүйн сургалт зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв, ТББ хамтрах	ТЗУХ, ХЗТ
58		Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжуудыг сурталчилах, аж ахуй нэгж байгууллага, иргэдэд хяналт, шалгалт, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ОБХ
59		Татвар төлөгчдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, татвар төлөх ач холбогдлыг таниулах, соён гэгээрүүлэх, татварын хууль тогтоомжийг сурталчлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон төвлөрсөн зах, худалдааны төвүүд, хороодод сурталчилгаа явуулж хийх, танхимын сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулна.	Сургалт Хамрагдсан иргэдийн тоо	20 2000	-	ТХ
60	4.1.5 Авлигын эсрэг эрс тууштай тэмцэж төрийн албаны хүнд суртал авлига хээл хахуулийг нийгмийн бүх салбарт таслан зогсооно.	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллана	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ТЗУХ
61	4.1.6 “Төрийн албан хаагчдыг сургах,	Төрийн албан хаагчдыг сургах,	Үйл ажиллагааны			

	мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж, хэрэгжүүлнэ.	мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана.	хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ТЗУХ
62	4.1.7 Дүүргийн төр захиргааны ордны номын сангийн фондыг өсгөн, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээг нэмэгдүүлнэ.	Дүүргийн номын сангийн үйл ажиллагааг сурталчлан жил бүр номын өдөрлөгт оролцон, номын сан хөмрөгийг нэмэгдүүлэх зорилгоор хандивын аян зохион байгуулж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ТЗУХ
63		Иргэдийн ном унших идэвхийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ТЗУХ
64	4.1.8 Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай баримт материалыг тоон хэлбэрт шилжүүлэн салбар бүрийн цахим мэдээллийн нэгдсэн сан /цахим архив/-г үүсгэнэ.	Байгууллагад хадгалагдаж байгаа цаасан баримтад үе шаттай цахим хувь үйлдэж, төрийн архивын нэгдсэн системийг сайжруулан цаасан болон цахим баримтын аюулгүй байдлыг хангана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ТЗУХ
65	4.1.9 Төрийн үйлчилгээний нэгдсэн програм хангамжийг хөгжүүлж, цахим мэдээллийн нэгдсэн сантай холбож, үйлчилгээнд нэвтрүүлнэ.	Төрийн үйлчилгээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэгдсэн програм хангамжийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж, цахим мэдээллийн нэгдсэн сантай холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв.	ТЗУХ
66	4.1.10 Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй цахим засгийг бодитой хэрэгжүүлнэ.	Шилэн дансыг хэрэгжүүлэн ажиллах байгууллага, албан тушаалтнуудын судалгааг нэгтгэн, иргэдэд шилэн дансны тухай хуулийг сурталчлан ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	СТСХ
67		Байгууллагуудын цахим хуудас, мэдээллийн самбараар тавигдах шилэн дансны мэдээлэлд хөндлөнгийн хяналтыг хагас жил тутамд хийж гүйцэтгэнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	СТСХ
68	4.1.11 "Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" нийслэлийн дэд хөтөлбөрийг дүүргийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг	"Хүн амын ахуйн үйлчилгээ 2020" нийслэлийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв.	ХХҮХ

	зохион байгуулна.					
4.2 Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр.						
69	4.2.1 Дүүргийн хэмжээнд “Архидан согтуурахтай тэмцэх” ажлыг сайжруулж, согтууруулах ундаа худалдаалан борлуулдаг, түүгээр үйлчилдэг газруудыг түвшин тогтоох үзлэгт тогтмол хамруулж хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Архи болон согтууруулах ундаагаар үйлчилдэг үйлчилгээний байгууллагуудын стандартын хэрэгжилтийг сайжруулах хяналт шалгалтыг зохион байгуулна.	Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын 60 аас доошгүй хувь	100	Орон нутгийн төсөв	ХХҮХ, МХХ, ЦХ
70	4.2.2 Хүнсний аюулгүй байдлын талаарх иргэдийн боловсрол, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалт сурталчилгаа зохион байгуулна.	“Худалдааны газар, түүний үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNDS 5021:2007” стандарт, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ, Хоолны газрын ангилал зэрэглэл, Үндсэн шаардлага MNS 4946:2005” стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ХХҮХ, НХХ, ЭМН
71	4.2.3 Дүүргээс олгодог тусгай эрх, зөвшөөрөл авахад тавигдах шаардлага, шалгуурыг хялбаршуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх гэрээ болон тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулж цахимжуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ХХҮХ
72	4.2.4 Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа түргэн үйлчилгээний цэгүүдийг олон улсын жишигт нийцүүлэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангуулна.	Нийслэлийн нутаг дэвсгэрт түргэн үйлчилгээний цэг ажлуулах журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ХХҮХ
ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ						
5.1 Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангаж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.						
73	5.1.1 Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх тогтолцоог бэхжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэнэ.	Ажил, мэргэжилгүй иргэдийг мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамруулж, мэргэшүүлж, ажлын байранд зуучилна.	Мэргэжлийн боловсролын болон сургалтын байгууллагыг төгсөгчид, тоо	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	НХХ, ХХҮХ
74	5.1.2 Оюутан, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэн, түр болон байнгын ажлын байраар хангана.	Их, дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг төгссөн мэргэжилтэй боловсон хүчнүүдийг төсөл хөтөлбөрт хамруулж ажлын	Ажлын байраар хангагдах оюутан, залуучуудын тоо	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	НХХ, ХХҮХ

		байраар хангах ажлыг зохион байгуулж ажиллана.				
75	5.1.3 “АЖИЛ ХАЙГЧ-ДҮҮРЭГ-АЖИЛ ОЛГОГЧ” гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	Хөдөлмөрийн чадвартай ажилгүй байгаа иргэд, ажил олоход бэрхшээлтэй байгаа иргэдийн судалгааг гаргаж иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг түргэн шуурхай хүргэх “Хөдөлгөөнт бирж”-ийн ажлын чанарыг шинэ түвшинд гаргаж дүүргийн ажилгүй иргэдийн мэдээллийн санг тогтмол баяжуулж ажиллана.	Шинээр бий болох ажлын байр, тоо болон ажилд зуучлагдсан иргэдийн тоо	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	НХХ, ХХҮХ
76	5.1.4 Аж ахуй эрхлэх санал санаачилгыг дэмжин, сургалт, төсөл хөтөлбөрт хамруулан, өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллана.	Иргэдийн санал санаачилгыг дэмжиж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг нэмэгдүүлнэ.	Дэмжлэг үзүүлэх иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тоо	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	НХХ, ХХҮХ
77	5.1.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авьяас, хөдөлмөр бүтээлийг үнэлж дэмжинэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Дэмжлэг үзүүлэх иргэдийн тоо	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	НХХ, ХХҮХ
78	5.1.6 Шинэ ажлын байр бий болгосон, ажлын байр нэмэгдүүлсэн ажил олгогчдыг дэмжих урамшууллын систем бий болгоно.	Дүүргийн хэмжээнд шинэ ажлын байр бий болгосон, ажлын байрыг нэмэгдүүлсэн ажил олгогчдыг дэмжин урамшуулах ажлыг зохион байгуулна.	Шинээр бий болох ажлын байр, тоо	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	НХХ, ХХҮХ
79	5.1.7 Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зах зээлийг өргөтгөх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодод үзэсгэлэн худалдаа зохион байгуулж оролцоно.	Холбогдох байгууллагуудтай хамтран үзэсгэлэн худалдаанд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан оролцуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ХХҮХ
80		Дүүргийн жижиг, дунд, хувиараа үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин, сурталчилах цахим сурталчилгааны ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж ажиллана.	Цахим суртчилгаанд 15 хорооны үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулна	100	-	ХХҮХ, ХМТ
81		Үндэсний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг сурталчлах, туршлага солилцох, зорилгоор дотоодын болон хөрш орнуудад зохион байгуулагдах	10-с дээш үзэсгэлэн худалдаанд 200 гаруй үйлдвэрлэл	100	Орон нутгийн	ЖДҮДТ, ХХҮХ

		үзэсгэлэн худалдааны мэдээллүүдийг тогтмол хүргэж оролцуулах, хамтран ажиллах, бизнесийн түншлэл тогтооход холбон зуучилна.	эрхлэгч хамруулан ажиллана.		төсөв 10.000.000	
82	5.1.8 Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжинэ.	Шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг мэргэжил арга зүйгээр ханган дэмжин ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ХХҮХ
5.2 Нийгмийн халамж үйлчилгээний чиглэлээр.						
83	5.2.1 Нийгмийн халамж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.	Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжинд хамрагддаггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдсан иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Халамжийн сан	НХХ, ХХҮХ
84	5.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд барилга байгууламж, зам талбайн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандартыг хангуулна.	Шинээр баригдах барилга, байгууламж, тохижилтын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн стандартыг хангуулахад хяналт шалгалтыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	МХХ, ХХҮХ
85	5.2.3 Дүүргийн Засаг даргын дэргэд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл” ажиллуулна.	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	НХХ, ХБИЗ
5.3 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.						
86	5.3.2 Төмс, хүнсний ногоо тариалах, жимс, жимсгэнэ ургуулах чиглэлээр аж ахуй эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, иргэдэд эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, худалдан борлуулах сүлжээг боловсронгуй болгоно.	Тариалсан бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих замаар иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлж үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ХХҮХ
87	5.3.3 Эрчимжсэн мал аж ахуй болон хүлэмжийн аж ахуй, фермерийн аж ахуй эрхлэх санал санаачилгыг дэмжинэ.	Фермерийн болон эрчимжсэн мал аж ахуй, хүлэмжийн аж ахуй, эрхлэгчдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв	ХХҮХ
5.4 Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр.						
88	5.4.1 Аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор дүүрэгт хотод соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр ажилладаг аж ахуйн нэгжүүдийг түшиглэн спорт, соёлын олон нийтийг хамарсан арга	Зохион байгуулах үйл ажиллагааны тоо	5	-	ХХҮХ

		хэмжээ зохион байгуулна.				
5.5 Иргэдийн газар өмчлөлийг бүрэн шийдэж, өмчилсөн газраа барьцаалан санхүүгийн эх үүсвэртэй болох боломжийг бүрдүүлнэ.						
89	5.5.1 Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулж газар эзэмшигч, ашиглагчийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, иргэнд үзүүлэх үйлчилгээг чанартай шуурхай болгож, газрын маргааныг бууруулна.	Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулж газар эзэмшигч, ашиглагчийн гэрээний биелэлтэнд хяналт тавьж, иргэнд үзүүлэх үйлчилгээг чанартай шуурхай үзүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ГА
5.6 Дүүргийн санхүүгийн эх үүсвэрийг иргэдийн оролцоотой төлөвлөж, иргэдэд нээлттэй болгоно.						
90	5.6.1 Улсын болон нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн санал хүсэлтийг харгалзан шийдвэрлэнэ.	Улс болон нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга, байгууламжийг ач холбогдлоор нь эрэмбэлэн, хөрөнгө оруулалтын ажлын саналыг холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ТГХШХ
91		Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын саналыг нийт 28 хорооны иргэдээс санал авч зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Орон нутгийн төсөв 5,000,000	ТГХШХ
92	5.6.2 Дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагууд цахим тайлангийн бүртгэл, нэгтгэлийг хуульд заасан хугацаанд тогтмол гарган.	Дүүргийн хэмжээнд шинээр нэмэгдэж байгаа болон нийт аж ахуйн нэгж байгууллагуудаас тайлан тэнцлийг цахим системд хүлээн авах, баталгаажуулах ажлыг нэмэгдүүлнэ.	Нийт ААН, байгууллагын тайлан хүлээн авах	100	Орон нутгийн төсөв	СТСХ
5.7 Тохилог орон сууц, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг хангах чиглэлээр.						
93	5.7.1 Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцыг иргэдийнх нь оролцоотойгоор дахин төлөвлөлт хийж барилгажуулах ажлыг дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцын барилгуудын барилгажилтын ажилд хяналт тавин ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв.	ТГХШХ
94	5.7.2 Гэр хорооллыг шинэ үзэл баримтлалын дагуу хөгжүүлж, иргэдэд боломжийн өртөгтэй орон сууцтай	Дүүрэгт хэрэгжиж буй шинэ үзэл баримтлалын дагуу гэр хорооллын дахин төлөвлөлтийн хэрэгжилтийг	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв.	ТГХШХ

	болох дахин төлөвлөлтийн системийг дэмжин ажиллана.	иргэдэд дэмжлэг үзүүлэхээр дээд шатны байгууллагатай хамтран ажиллана.				
95		Газар шинэчлэн зохион байгуулах төслийг дээд шатны байгууллагуудтай хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Нийслэлийн төсөв.	ТГХШХ
96	5.7.3 Угсармал орон сууцны дулаан алдагдлыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд дулаан алдагдалтай байгаа орон сууцны судалгааг хороо тус бүрээр гаргаж дээд шатны байгууллагад уламжлах, дэвшилтэд технологийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулна	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Улс, нийслэлийн төсөв.	ТНААХ Хороод
97	5.7.4 Амгалан дулааны станцын үр ашгийг дээшлүүлэх, дулааны төв шугамтай холбох замаар хотын зүүн хэсгийн дулаан хангамжийг сайжруулна.	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд дулаанд холбогдох хүсэлтэй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн судалгааг гаргаж холбогдох мэргэжлийн байгууллагуудад саналаа хүргүүлж, хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	Улс. нийслэлийн төсөв.	ТНААХ Хороод
98	5.7.5 Гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр үе шаттай хангана.	Гэр хорооллын гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах үүднээс хүчдэлийн уналттай болон цахилгаангүй өрхийн судалгааг гаргаж дээд шатны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	-	ТНААХ Хороод
99	5.7.6 Гэр болон Орон сууцны хороолол доторх явган замд гэрэлтүүлэг хийх ажлыг эрчимжүүлж, сайжруулна.	Нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гудамж, зам талбайд хийгдэх гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, хэрэгжиж буй ажилд хяналт тавьж ажиллана.	Шинээр нэмэгдсэн гэрэлтүүлэгийн тоо	600 ширхэг	Нийслэл, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө	ТНААХ
100	5.7.7 Дүүргийн гэр хороолол болон орон сууцны хороолол доторх нийтийн эзэмшлийн гудамж, талбай, замыг засаж сайжруулах ажлыг эрчимжүүлнэ	Гол болон туслах гудамж замууд, тэдгээрийг холбосон авто замын ажилд хяналт тавьж ажиллана.	Ажлын явц, хувиар	100	Улс, нийслэлийн төсөв	ТНААХ
101		Гэр хорооллын гудамж дундах авто замыг хусаж тэгшлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Ажлын явц, хувиар	100	Орон нутгийн төсөв	ТНААХ

102	5.7.8 Авто зогсоолцын хүрэлцээ муутай орон сууцны хорооллын дунд тохижилт бүхий газар доорх авто зогсоолын төслийг хэрэгжүүлнэ.	Орон сууцны хорооллын дунд тохижилт бүхий газар доорх авто зогсоолын төслийг дэмжин ажиллана.	Ажлын явц, хувиар	100	Хувийн хэвшил	ТГХШХ
-----	---	---	----------------------	-----	---------------	-------

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2017 он